



Онлайн сургалтын үнэлгээний хэрэгслүүдийн талаарх тойм судалгаа

Цэндсүрэн Нямсүрэн 

Монгол Улсын Боловсролын Их сургууль

Лхагвасүрэн Мөнхтуяа 

Монгол Улсын Боловсролын Их сургууль

Батсуурь Бадамсүрэн 

Монгол Улсын Боловсролын Их сургууль

<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Нямсүрэн, Ц., Мөнхтуяа, Л., Бадамсүрэн, Б. (2026). Онлайн сургалтын үнэлгээний хэрэгслүүдийн талаарх тойм судалгаа. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 31(1).

<https://doi.org/10.56380/mjer.v31.1.2>

A Review of Online Learning Evaluation Instruments in Higher Education

Nyamsuren Tsendsuren 

Mongolian National University of Education

Munkhtuyal Lkhagvasuren 

Mongolian National University of Education

Badamsuren Batsuuri 

Mongolian National University of Education

To cite this article:

Tsendsuren, N., Lkhagvasuren, M., Batsuuri, B. (2026). A Review of Online Learning Evaluation Instruments in Higher Education. *Mongolian Journal of Educational Research*, 31(1).

<https://doi.org/10.56380/mjer.v31.1.2>

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Онлайн сургалтын үнэлгээний хэрэгслүүдийн талаарх тойм судалгаа

Цэндсүрэнгийн Нямсүрэн, Лхагвасүрэнгийн Мөнхтуяа, Батсуурийн Бадамсүрэн

Өгүүллийн мэдээлэл

Түүх:

Хүлээн авсан: 2026.01.07
Засаж сайжруулсан: 2026.03.24
Хэвлэхийг зөвшөөрсөн: 2026.03.30

Түлхүүр үг:

Онлайн сургалт
Үнэлгээний хэрэгсэл
Рубрик
Психометрийн баталгаажуулалт
Дээд боловсрол

ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд онлайн сургалт дээд боловсролын сургалтад түгээмэл хэрэглэгдэх болсон ч түүний чанарыг үнэлэх нэгдмэл ойлголт, найдвартай хэрэгсэл хангалтгүй хэвээр байна. Иймээс энэхүү судалгаагаар дээд боловсролын онлайн сургалтыг үнэлэхэд түгээмэл ашиглагддаг олон улсын 11 хэрэгслийг баримт бичгийн шинжилгээний аргаар харьцуулж, нийтлэг болон ялгаатай талуудыг тодорхойлохыг зорив. Судалгааны үр дүнгээс харахад ерөнхий мэдээлэл/танилцуулга, үнэлгээ зэрэг шалгуурууд бүх хэрэгсэлд нийтлэг байсан бол суралцагчийн оролцоо/харилцаа, сургалтын материал, агуулга, үйл ажиллагаа өндөр давтамжтай илэрсэн. Харин технологи, хэрэгсэл, хүртээмж, суралцагчийн дэмжлэг, эргэх холбоо зэрэг шалгуурууд харилцан адилгүй байсан нь үнэлгээний зорилго, хэрэглэх нөхцөлөөс хамаарч байгааг илтгэнэ. Мөн ихэнх хэрэгслийн хувьд найдвартай, хүчинтэй байдлын талаарх мэдээлэл хомс байгаа нь тэдгээрийг судалгааны хэмжүүр болгон ашиглахад анхаарах шаардлагатайг харуулж байна. Манай улсад онлайн сургалтын талаарх судалгаа нэмэгдэж буй хэдий ч өргөн хэрэглэгддэг, баталгаажсан үнэлгээний хэрэгсэл ховор байгаа тул цаашид олон улсын туршлагад тулгуурласан, Монголын нөхцөлд нийцсэн хэрэгслийг боловсруулах, хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:

Лхагвасүрэнгийн Мөнхтуяа
Захиргаа, хүний нөөцийн газар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль
Мэйл хаяг: munkhtuya@msue.edu.mn

A Review of Online Learning Evaluation Instruments in Higher Education

Nyamsuren Tsendsuren, Munkhtuya Lkhagvasuren, Badamsuren Batsuuri

Article information

Article history:

Received: Jan 01, 2026
Revised: Mar 24, 2026
Accepted: Mar 30, 2026

Keywords:

Online Learning
Evaluation instruments
Rubric
Psychometric validation
Higher education

ABSTRACT

In recent years, online learning has become widely used in higher education; however, unified conceptual frameworks and reliable instruments for evaluating the quality of online learning remain insufficient. Therefore, this study aims to compare 11 internationally recognized instruments commonly used to evaluate online learning in higher education and to identify their shared and distinctive characteristics through document analysis. The findings indicate that criteria related to general information/overview and assessment are common across all instruments, while learner interaction/engagement and learning materials, content, and activities appear with high frequency. In contrast, criteria associated with technology and tools, accessibility, learner support, and feedback vary considerably, suggesting that evaluation approaches differ depending on evaluation purposes and contexts of use. Moreover, limited reporting on the reliability and validity of most instruments highlights the need for caution when they are used as research measures. Although research on online learning in Mongolia has increased in recent years, widely used and validated evaluation instruments remain scarce. Accordingly, there is a need to develop and validate evaluation instruments grounded in international experience and adapted to the Mongolian higher education context.



This is an open access article under the Creative Commons Attribution-Non Commercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:

Lkhagvasuren Munkhtuya
Administrative Division, Mongolian National University of Education
Email: munkhtuya@msue.edu.mn

УДИРТГАЛ

Онлайн сургалт дэлхий даяар хурдацтай өргөжиж, дээд боловсролын сургалтад тогтвортой байр суурь эзлэх боллоо. Мартин нарын (2020) тойм судалгаанд 2009-2018 оны хооронд онлайн болон цахим сургалтын талаарх судалгааны тоо гурав дахин өссөнийг тэмдэглэсэн нь энэ чиглэлийн судалгаа эрчимжиж, онлайн сургалтыг үнэлэх асуудал бодит хэрэгцээ болж байгааг илтгэнэ. COVID-19 цар тахал нь онлайн сургалтын хүртээмж, хамрах хүрээг тэлсэн боловч түүнийг үнэлэх нэгдмэл ойлголт, найдвартай үнэлгээний хэрэгслүүд хангалттай бус байгааг судлаачид онцолж байна (Мөнхдэлгэр нар, 2025, Meng et al., 2024). Алтуркистан (2020) нарын МООС үнэлгээний аргуудын талаарх системчилсэн тойм судалгаагаар онлайн сургалтыг үнэлэхэд ашиглагдаж буй хэрэгсэл олон боловч тэдгээрийн нэгдмэл байдал дутагдалтай байгааг тодорхойлсон байна. Үнэлгээний хэрэгслүүд нь нийтлэг зорилготой ч дотоод бүтэц, шалгуурын багц, ашиглахад шаардагдах нотолгоо, үнэлэх логик зэргээсээ хамаарч хоорондоо ихээхэн ялгаатай байдаг. Үүний улмаас их, дээд сургуулиуд өөрийн нөхцөлд аль хэрэгсэл илүү тохирох талаар системтэй шийдэхэд хэрэг болох харьцуулсан нотолгоо дутмаг байна. Түүнчлэн, зарим хэрэгсэл нь агуулга эсвэл суралцагчийн оролцоо зэрэг тодорхой нэг зүйлд төвлөрөх хандлагатай тул хичээлийг бүхэлд нь хамарсан цогц зураглал бүрэн өгч чаддаггүйг МкИннес нарын (2024) судалгаанд дурдсан байна. Уг өгүүлэлд өргөн хэрэглэгддэг үнэлгээний хэрэгслүүдийг харьцуулан судалж, онлайн сургалтыг үнэлэх шалгуурын онцлог, ялгаатай болон ижил талуудыг тодруулахыг зорив.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Олон улсад Quality Matters (QM), Open SUNY Course Quality Review (OSCQR), Canvas Course Evaluation Checklist (CCEC) зэрэг үнэлгээний хэрэгслүүд бий болж, онлайн сургалтын бүтэц, агуулга, багшлах арга зүй, суралцагчийн оролцоог системтэйгээр хэмжих оролдлого хийсээр байна (Baldwin & Ching, 2019; Martin et al., 2021; Matolić et al., 2023; Sun et al., 2023). Эдгээр хэрэгсэл нь онлайн сургалтын гол бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхой шалгуураар үнэлэх, сайжруулахад чиглэсэн хүрээг санал болгодог бөгөөд тэдгээр нь зорилго, онолын суурь, шалгуурын бүтэц, үнэлэх логик, хэрэглээний нөхцөлийн хувьд мэдэгдэхүйц ялгаатай. Гэсэн хэдий ч эдгээр судалгаанууд нь ихэвчлэн үнэлгээний хэрэгслүүдийн бүтэц, шалгуурын агуулгыг тодорхойлох, танилцуулахад төвлөрсөн бөгөөд хэрэгслүүдийн онолын суурь, үнэлгээний зорилго, хэрэглээний нөхцөлөөс үүдэлтэй ялгааг харьцуулан шүүмжлэлтэй авч үзсэн судалгаа харьцангуй ховор байна. Жишээлбэл, QM нь стандартын биелэлт, сургалтын дизайны чанарт төвлөрдөг бол OSCQR нь сургалтыг сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн зөвлөмжийн шинжтэй байдаг. Ийм ялгаа нь хэрэгслүүдийг ижил шалгуураар шууд харьцуулахад хязгаарлалт үүсгэж болох бөгөөд цаашид эдгээр ялгааг онолын түвшинд тайлбарлах шаардлагатай. Мөн Зиммерман нарын (2020) судалгаагаар эдгээр хэрэгслийн психометрийн баталгаажуулалт болон хэрэгжилтийн нөхцөл улс орон бүрд харилцан адилгүй байгааг онцолсон нь тухайн хэрэгслийг шууд хуулбарлах бус, өөрсдийн хэрэглээний бодит нөхцөл, хэрэгцээнд тохируулан зохиомжлох шаардлагатайг харуулж байна.

Монголын их, дээд сургуулиудад онлайн сургалтын хэрэгжилт, чанар, бүтцийг үнэлэх чиглэлийн судалгаанууд сүүлийн жилүүдэд эрчимжиж байгаа ч уг чиглэлд хамаарах судалгаа харьцангуй шинэлэг байна. Сувдмаа нар 2016 онд сургалт удирдлагын системийн хэрэглээ, байгууллагын дэмжлэг, багшийн туршлага зэрэг хүчин зүйлс нь онлайн сургалтын хэрэгжилтэд мэдэгдэхүйц нөлөөтэйг тогтоосон бол 2023 онд 700 гаруй багш оролцсон өргөн хүрээтэй тоон судалгаа хийж, байгууллага болон хувь хүний хүчин зүйлсийн нөлөөллийг статистик аргаар үнэлсэн байна. COVID-19 цар тахлын үед онлайн сургалтын чанар, хүртээмжтэй холбоотой асуудлууд илүүтэй тавигдсан бөгөөд тухайлбал, Доржпүрэв нар (2020) оюутнуудын технологийн хэрэглээ, багшийн заах арга, хэрэглэгдэхүүний хүрэлцээ зэрэг хүчин зүйлсийг онцолжээ. Онлайн сургалтын бэлэн байдлын үнэлгээний талаар Итгэл нар (2022) оюутнуудын техник болон харилцааны чадамж, багш болон хамт олонтой харилцах чадвар нь онлайн сургалтад шууд нөлөөлдөг болохыг нотолсон байна. Мөнхдэлгэр нар (2025) онлайн сургалтын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг судалж, нийгэм-сэтгэлзүйн болон арга зүйн хүчин зүйлсийг цогцоор авч үзэх шаардлагатайг онцолжээ. Онлайн сургалтын платформ, сургалт удирдлагын системийн чанартай холбоотой Батхуяг нар (2024) МУБИС-ийн LMS системийн хэрэглээ, технологийн дэмжлэг, оюутны сэтгэл ханамж зэрэг хэмжүүрүүдээр дамжуулан байгууллагын түвшний дэмжлэг ба үйлчилгээний чанарыг үнэлж, тэдгээрийн ач холбогдлыг авч үзжээ.

Хүснэгт 1. Монголын судалгааны чиглэл ба арга зүй(n=17)

Судалгааны чиглэл	Тоо	Зохиогч (он)	Арга зүй
Онлайн сургалтын бэлэн байдал	4	Итгэл нар (2022), Буяндэлгэр нар (2022), Сувдмаа нар (2023), Алтангэрэл нар (2023)	Тоон судалгаа
Хэрэгжүүлэлт, сорилт	3	Сувдмаа нар (2016, 2023), Алтангэрэл нар (2023)	Холимог арга
Чанарын үнэлгээ	3	Уранчимэг нар (2021), Ганцэцэг нар (2023)	Кэйс судалгаа
Багшлах арга зүй	4	Бадамсүрэн нар (2019, 2025), Тана нар (2023), Батцэцэг (2024)	Квази-туршилт, хичээлийн дизайн
Оюутны туршлага, хандлага, сэтгэл ханамж	3	Отгонцэцэг нар (2018), Доржпүрэв (2020), Батхуяг (2024), Мөнхдэлгэр нар (2025)	Судалгаа

Хүснэгт 1-д Монголын судлаачдын онлайн сургалтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн 17 судалгааг судалгааны чиглэл болон арга зүйн хувьд нэгтгэн харууллаа. Үр дүнгээс харахад судалгаанууд онлайн сургалтын бэлэн байдал (n=4) болон багшлах арга зүй/сургалтын аргачлалын туршилт (n=4) чиглэлд хамгийн их төвлөрсөн байна. Үүнээс гадна онлайн сургалтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл (n=3), чанарын үнэлгээ (n=3), мөн оюутны туршлага, хандлага, сэтгэл ханамжийн судалгаа (n=3) нь дунд түвшний давтамжтай ажиглагдлаа. Арга зүйн хувьд бэлэн байдлын судалгаанд тоон арга давамгайл (асуумж/статистик шинжилгээ), хэрэгжүүлэлтийн талаарх судалгаанд холимог арга, чанарын үнэлгээний судалгаанд кейс судалгаа, багшлах арга зүйн чиглэлд квази-туршилтын загвар түлхүү ашиглажээ.

Ерөнхийд нь авч үзвэл Монголын дээд боловсролын хувьд онлайн сургалт сүүлийн арван жилд аажмаар нэмэгдсэн ч COVID-19 үеэр огцом эрчимжиж, судалгааны чиглэл мөн түүнтэй зэрэгцэн өөрчлөгдөж байна. Эхний үе шатанд судалгаанууд хэрэгжилт, дэд бүтэц, байгууллагын дэмжлэг, багш-суралцагчийн бэлэн байдалд төвлөрч байсан бол, цар тахлын болон дараах үед суралцах туршлага, сэтгэл ханамж, багшид тулгамдсан асуудал, хичээлийн бүтэц, үнэлгээний зохион байгуулалт зэрэг чанарын асуудлыг илүүтэй тусгажээ. Сүүлийн жилүүдэд хичээлийн чанарын үнэлгээний загвар, хэрэгслийг боловсруулах эхлэл тавигдаж байгаа боловч ихэнх нь нэг байгууллага, нэг курс/хөтөлбөрийн түвшинд хязгаарлагдсан, мөн олон улсын хэрэгслүүдтэй системтэй харьцуулж баталгаажуулсан судалгаа цөөн байна.

АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаанд онлайн сургалтыг үнэлэх хэрэгслүүдийн нийтлэг болон ялгаатай шинжийг тодорхойлох зорилгоор баримт бичгийн шинжилгээний арга ашиглав. Судалгаанд нийт 11 хэрэгслийг (QLT, UNM, QM, UWLA, CCEC, UMPI, SHSU, OSCQR, 5PQR, ANTHO, EOQR) хамруулж, хэрэгсэл бүрийн баримт бичиг болон тухайн хэрэгслийг тайлбарласан эх сурвалжууд дээр тулгуурлан харьцуулалт хийлээ. Хэрэгслүүдийг сонгохдоо (1) дээд боловсролын сургалтад хэрэглэх боломжтой байх, (2) шалгуурын бүтэц тодорхой байх, (3) баримт бичиг нь олон нийтэд нээлттэй эсвэл эх сурвалжаар ашиглах боломжтой байх гэсэн шалгуурыг баримталсан.

ҮР ДҮН

Энэхүү өгүүлэлд онлайн хичээлийн чанар, сургалтын дизайн, хэрэгжилтийг үнэлэхэд өргөн хэрэглэгддэг 11 хэрэгслийн ерөнхий мэдээллийг нэгтгэн харууллаа. Хүснэгт 2-оос харахад онлайн сургалтыг үнэлэх хэрэгслийн ихэнх нь их сургууль, байгууллагын дотоод хэрэглээнд зориулан боловсруулсан рубрик болон шалгуурын хүснэгт хэлбэртэй байна. Үнэлгээний хэмжүүр нь а. түвшин тогтоох (жишээ нь, хийж байгаа, хийсэн, үлгэр жишээ г.м), б. шаардлага хангаж буй эсэхийг шалгах (хангасан/хангаагүй, байгаа/байхгүй), в. оноо бүхий (1-3, 1-5) гэсэн үндсэн төрлөөр ялгаатай байгаа нь ажиглагдав. Энэ нь хэрэгслүүдийн зорилго, хэрэглэх нөхцөл, үнэлгээ хийх шинжээчээс шалтгаалан үнэлэх хэмжүүрийг олон хэлбэрээр зохион байгуулдаг байна.

Хүснэгт 2. Үнэлгээний хэрэгслийн ерөнхий мэдээлэл

№	Үнэлгээний хэрэгсэл	Товч нэр	Эх сурвалж	Найдвартай байдал/ Cronbach α	Үнэлэх хэмжүүр
1	Rubric for online course evaluation	QLT	California State University (csuchico.edu)	> 0.80 (Newsome, 2022)	Хийж байгаа, үр дүнтэй хийсэн, үлгэр жишээ
2	Online Course Standards Rubric	UNM	University of New Mexico (ctl.unm.edu)	-	Шилдэг туршлага, хийсэн
3	QM Higher Education Rubric	QM	Quality matters (qualitymatters.org)	> 0.79 (Lin, 2023)	Шалгуур бүр тусдаа оноотой(1-3)
4	UW-La Crosse Online Course Evaluation	UWLA	Univ. of Wisconsin–La Crosse (uwlax.edu)	-	Байгаа, байхгүй
5	Canvas Course Evaluation Checklist	CCEC	Miranda McIntosh (community.instructure.com)	-	Зайлшгүй, шилдэг туршлага, үлгэр жишээ
6	Online course evaluation rubric	UMPI	Univ of Maine at Presque Isle (umpi.edu)	-	3- заавал биелүүлэх доод шаардлага, 1- санал болгож буй шаардлага
7	Rubric for Online Course Design	SHSU	Sam Houston State University (shsu.edu)	-	Хийж байгаа, хийсэн, үлгэр жишээ
8	Online Course Quality Review Rubric	OSCQR	Online Learning Consortium, Inc. (online.suny.edu)	0.923 (Briones, 2023)	0-Байхгүй, 1-хийж байгаа, 2-хийсэн, 3- үлгэр жишээ
9	5 Pillars Quality Course Review Rubric	5PQR	Missouri System (v8, 2025) (teaching.missouri.edu)	-	Хангасан, хангаагүй
10	Anthology Exemplary Course Program Rubric	ANTHO	Anthology Inc. (anthology.com)	-	Шалгуур бүр тусдаа оноотой(1-5).
11	Engaged online course rubric	EOCR	University of Tennessee, Knoxville (digitalllearning.utk.edu)	-	Тийм, үгүй

Үнэлгээний хэрэгсэл нь судалгааны асуумж бус, практикт ашиглах хэлбэрээр хөгжсөн тул психометрийн үзүүлэлтийг (найдвартай байдал, хүчин төгөлдөр байдал) заавал үнэлэхгүй байх хандлагатай. Иймээс тэдгээр хэрэгслийн найдвартай байдал, хүчин төгөлдөр байдлыг шалгаж, үр дүнг нийтэд ил тод мэдээлсэн тохиолдол ховор бөгөөд Ли нар (2020) судалгаандаа үнэлгээний рубрикийн найдвартай, хүчин төгөлдөр байдлыг шалгасан үр дүнг олон нийтэд мэдээлсэн нь бараг байхгүй, зарим нь туршилт хийсэн гэж дурдсан ч дэлгэрэнгүй үр дүнгээ нийтлээгүй байна гэжээ. Манай судалгаанд хамруулсан хэрэгслүүдээс психометрийн үр дүнг тодорхой тайлагнасан нь цөөн

Хүснэгт 3. Онлайн сургалтын үнэлгээний хэрэгслийн харьцуулалт

Үнэлгээний хэрэгсэл	QLT	UNM	QM	UWLA	CCEC	UMPI	SHSU	OSCQR	5PQR	ANTHO	EOCR
Үүссэн он	2003	2013	2003	2010	2018	-	2002	2014	-	2000	2021
Сүүлийн хувилбар	2014	2021	2023	2023	2023	2024	2024	2024	2025	2025	2025
Бүлэг	5	5	8	5	8	8	5	6	5	4	7
Шалгуур	20	28	44	23	66	29	28	50	52	53	40
Хуудасны тоо	5	21	1	5	7	3	23	5	15	5	4
Шалгуурын бүлэг	Хичээлийн зохион байгуулалт, дизайн	Хичээлийн ерөнхий мэдээлэл, танилцуулга	Хичээлийн ерөнхий мэдээлэл, танилцуулга	Хичээлийн ерөнхий мэдээлэл, агуулга	Хичээлийн ерөнхий мэдээлэл, гарах үр дүн	Хичээлийн ерөнхий мэдээлэл, танилцуулга	Хичээлийн зохион байгуулалт	Хичээлийн ерөнхий мэдээлэл, танилцуулга	Сургалтын зорилго	Хичээлийн дизайн	Хичээлийн ерөнхий мэдээлэл, танилцуулга
	Сургалтын дизайн, агуулга	Суралцахуйн элемент	Сургалтын зорилго	Сургалтын зорилго, суралцагчийн оролцоо	Хичээлийн бүтэц	Сургалтын зорилго	Сургалтын зорилго	Технологи хэрэгсэл	Суралцагчийн оролцоо, харилцаа	Суралцагчийн оролцоо, харилцаа	Үнэлгээ, эргэх холбоо
	Үнэлгээ, сургалтын зорилго	Суралцагчийн оролцоо, харилцаа	Үнэлгээ	Суралцагчийн дэмжлэг/хүртээмж	Хичээлийн агуулга	Үнэлгээ	Multimedia, хэрэгсэл	Дизайн/харагдах байдал	Сургалтын зорилго ба үнэлгээ	Үнэлгээ	Хичээлийн агуулга ба үйл ажиллагаа
	Технологи, хэрэгсэл	Үнэлгээ	Сургалтын материал	Суралцагчийн харилцаа	Суралцагчийн харилцаа	Сургалтын материал, агуулга, эх сурвалж	Суралцагчийн оролцоо, харилцаа	Агуулга ба үйл ажиллагаа	Технологи, суралцагчийн дэмжлэг, хүртээмж	Суралцагчийн дэмжлэг	Суралцагчийн харилцаа
	Эргэх холбоо	Эргэх холбоо	Сургалтын үйл ажиллагаа, суралцагчийн харилцаа	Үнэлгээ, эргэх холбоо	Үнэлгээ	Суралцагчийн оролцоо	Үнэлгээ	Суралцагчийн харилцаа	Хичээлийн бүтэц		Суралцагчийн дэмжлэг
			Технологи		Бусад эх сурвалж		Хичээлийн зохион байгуулалт, технологи, хэрэгсэл		Үнэлгээ, эргэх холбоо		Технологи хэрэгсэл
			Суралцагчийн дэмжлэг		Хүртээмж		Суралцагчийн дэмжлэг				Хүртээмж
		Хүртээмж		Багшийн дэмжлэг		Хүртээмж					

бөгөөд жишээлбэл, QLT-д суурилсан 27 хэмжээстэй оюутны асуумжийн дэд хэмжээсүүдийн кронбах альфа 0.751–0.937 (Newsome, 2022), OSCQR-ийн 50 хэмжээстэй асуумжийн кронбах альфа 0.923 (Briones, 2023), мөн QM-д суурилан боловсруулсан оюутны оролцооны асуумжийн дэд хэмжээсүүдийн кронбах альфа 0.79–0.91 (Lin, 2023) хүрээнд гарсан байна.

Иймээс үнэлгээний хэрэгслүүд олон боловч найдвартай байдлыг ил тод нийтэлсэн нотолгоо ховор байгаа нь цаашид шинэ хэрэгсэл боловсруулах, мөн одоогийн хэрэгслийг судалгааны хэмжүүр болгон хэрэглэхэд анхаарах суурь асуудал болж байна.

Хүснэгт 3-д онлайн сургалтыг үнэлэх 11 хэрэгслийг үүссэн он, сүүлийн хувилбар, бүлэг, шалгуурын тоо, баримтын хэмжээ, мөн шалгуурын бүлэг зэрэг үзүүлэлтээр харьцуулан нэгтгэв. Эдгээр үнэлгээний хэрэгслүүдийг 2000-2021 онд боловсруулсан бөгөөд 2023-2025 онд сайжруулан шинэчилжээ. Энэ нь онлайн сургалтын хөгжилтэй уялдан хэрэгслийн шинэчлэлт, хэрэглээний идэвхжил сүүлийн жилүүдэд нэмэгдсэнийг харуулж байна.

Бүлэг болон шалгуурын тооны хувьд хэрэгслийн нарийвчлал, хамрах хүрээ мэдэгдэхүйц ялгаатай. Бүлгийн тоо 4-8 хооронд хэлбэлзэж байгаа бол шалгуурын тоо 20-66 хооронд байна. Өөрөөр хэлбэл, зарим хэрэгсэл (жишээ нь, CCEC, OSCQR, SPQR, ANTHO) олон шалгуураар дэлгэрэнгүй зураглал гаргахыг зорьдог бол, бусад нь (жишээ нь, QLT, UWLA) харьцангуй цөөн шалгуураар гол шаардлагуудыг үнэлэх бүтэцтэй байна. Баримтын хэмжээ ч ялгаатай бөгөөд нэг хуудас мэт маш товч рубрикээс эхлээд 21-23 хуудас хүртэл дэлгэрэнгүй тайлбар, жишээтэй баримт бичигтэй хэрэгсэл ч байна. Энэ ялгаа нь хэрэгслийн зориулалт (шалгах эсвэл нарийвчилсан үнэлгээ, сайжруулалт хийх) болон хэрэглэгчийн бүлэг (багш өөрөө ашиглах эсвэл шинжээч)-тэй холбоотой гэж үзэж болно.

Хүснэгт 4. Үнэлгээний хэрэгслүүдэд илэрсэн шалгуурын бүлгүүдийн тархалт (N=11)

№	Шалгуурын бүлэг	QLT	UNM	QM	UWLA	CCEC	UMPI	SHSU	OSCQR	SPQR	ANTHO	EOCR	Давтамж (n/11, %)
1	Ерөнхий мэдээлэл	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	11/11 (100%)
2	Үнэлгээ	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	11/11 (100%)
3	Суралцагчийн оролцоо/ харилцаа		+	+	+	+	+	+	+	+	+	+	10/11 (90.9%)
4	Сургалтын материал, агуулга, үйл ажиллагаа	+	+	+		+	+	+	+			+	9/11 (81.8%)
5	Технологи, хэрэгсэл	+		+			+	+	+	+		+	7/11 (63.6%)
6	Эргэх холбоо	+	+		+	+			+			+	6/11 (54.5%)
7	Суралцагчийн дэмжлэг			+	+		+			+	+	+	6/11 (54.5%)
8	Хүртээмж			+	+	+	+			+		+	6/11 (54.5%)
9	Сургалтын зорилго	+		+	+		+	+		+			6/11 (54.5%)
10	Сургалтын зохион байгуулалт, бүтэц, дизайн	+				+	+		+		+		5/11 (45.5%)
11	Бусад эх сурвалж					+							1/11 (9.1%)
12	Багшийн дэмжлэг					+							1/11 (9.1%)

Хүснэгт 4-д судалгаанд хамруулсан 11 үнэлгээний хэрэгсэлд шалгуурын бүлгүүд хэр давтагдаж байгааг (+) тэмдгээр, нийт давтамжийг n/11 (%) хэлбэрээр нэгтгэн үзүүлэв. Шалгуурын нэр томьёо, бүлэг нь сургууль бүрийн стандарт, бодлогоос хамааран ялгаатай байсан тул хүснэгтэд яг адил нэршлээр нь бус, утга агуулгаар нь нэгтгэн кодчилж давтамжийг тооцсон.

Үр дүнгээс харахад ерөнхий мэдээлэл, үнэлгээ бүлгүүд бүх хэрэгсэлд (11/11, 100%) давтагдсан бол суралцагчийн оролцоо/харилцаа (10/11, 90.9%), сургалтын материал, агуулга, үйл ажиллагаа (9/11, 81.8%) өндөр давтамжтай илэрч байна. Харин технологи, хэрэгсэл (7/11, 63.6%) эргэх холбоо, суралцагчийн дэмжлэг, хүртээмж (тус бүр 6/11 54.5%) зэрэг шалгуурууд хэрэгслийн хооронд

харилцан адилгүй тусгагдсан байна. Энэ нь онлайн сургалтын чанарын үнэлгээнд нийтлэг үндсэн хэмжүүрүүдээс гадна хэрэглээний нөхцөл, зорилгоос хамаарсан ялгаа байгааг илтгэнэ.

Түүнчлэн эргэх холбоо, суралцагчийн дэмжлэг, хүртээмж, сургалтын зорилго бүлгүүд тус бүр 6/11 (54.5%) байгаа нь чанарын үнэлгээнд зөвхөн агуулга төдийгүй суралцагчийн дэмжлэг, хүртээмж, суралцагчийн санал, эргэх холбоо, сургалтын зорилгын тодорхой байдал зэрэг суралцах үйл явцыг дэмжих, сайжруулах хэмжүүрүүд чухал болж буйг харууллаа. Сургалтын зохион байгуулалт, бүтэц, дизайн”, “Багшийн дэмжлэг”, “Бусад эх сурвалж” зэрэг бүлгүүд маш бага давтамжтай илэрсэн нь уг ойлголт зарим хэрэгсэлд “ерөнхий мэдээлэл /агуулга /үйл ажиллагаа” зэрэг бусад бүлгүүдийн дотор шингэсэн, эсвэл их дээд сургууль бүр өөр нэршил, бүтэцтэйгээр тусгадагтай холбоотой байж болох юм.

Эдгээр үр дүн нь их дээд сургуулийн онцлог, зорилго, хэрэглэх нөхцөлөөс үл хамааран ерөнхий мэдээлэл, үнэлгээ, суралцагчийн оролцоо/харилцаа, агуулга/үйл ажиллагаа гэсэн үндсэн тулгуур хэмжүүрүүд дээр онлайн сургалтын үнэлгээний хэрэгслүүд төвлөрч байгааг илэрхийлж байна. Иймээс үндэсний эсвэл их дээд сургуулийн түвшинд шинэ хэрэгсэл боловсруулах үед эдгээр өндөр давтамжтай бүлгүүдийг багц болгон төлөвлөж, харин технологи, хүртээмж, дэмжлэг, эргэх холбоо зэрэг хэмжүүрийг сургуулийн бодлого, хэрэглэгчийн хэрэгцээ, сургалтын загвартай уялдуулан авч үзэх нь оновчтой байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад онлайн сургалтын үнэлгээний хэрэгсэлд ерөнхий мэдээлэл, суралцагчийн оролцоо, үнэлгээ зэрэг шалгуурын бүлгүүд давхцаж байгаа нь өмнөх тойм судалгаануудын дүгнэлттэй нийцсэн (McInnes et al., 2024; Martin et al., 2020). Гэсэн хэдий ч эргэх холбоо, хүртээмж, суралцагчийн дэмжлэг зэрэг суралцах үйл явцыг дэмжих хэмжүүрүүд харилцан адилгүй байгаа нь үнэлгээний хэрэгсэл ихэвчлэн их, дээд сургуулийн дотоод хэрэгцээнд чиглэсэн, сайжруулах бус хянах зорилго давамгайл байгаатай холбоотой байж болно. Мөн судалгаанд хамрагдсан хэрэгслийн дийлэнх нь психометрийн баталгаажуулалтын үр дүнг нийтлээгүй нь өмнөх судалгаанд дурдсан асуудлыг дахин нотолж байгаа (Zimmerman et al., 2020) бөгөөд тэдгээр хэрэгслийг судалгааны хэмжүүр болгон ашиглахад болгоомжтой хандах шаардлагатайг харуулж байна.

Монголын нөхцөлд онлайн сургалтын чанарыг үнэлэхэд эдгээр хэрэгслийг шууд хуулбарлан хэрэглэхээс илүүтэйгээр нийтлэг давтамжтай илэрсэн шалгууруудыг суурь болгон, өөрсдийн онцлогт нийцүүлэн шинэ хэрэгсэл боловсруулах нь оновчтой гэж үзэж байна. Энэхүү судалгаа нь баримт бичгийн шинжилгээнд суурилсан тул бодит хэрэглээний үр нөлөөг үнэлээгүй нь хязгаарлалт болж магадгүй. Иймээс цаашдын судалгаа нь туршилтын хэрэгжилт болон эмпирик баталгаажуулалтад чиглэх шаардлагатай.

ДҮГНЭЛТ

Монголын нөхцөлд онлайн сургалтын талаарх судалгаа эхэн үедээ бэлэн байдал, хэрэгжилтийн нөхцөл, оролцогчдын туршлагад төвлөрч байсан бол сүүлийн жилүүдэд хичээлийн бүтэц, чанарыг оношлох, үнэлгээний хэрэгсэл боловсруулах чиглэл рүү шилжиж байна. Гэсэн хэдий ч психометрийн баталгаажуулалттай, өргөн хэрэглэгдэхүйц үнэлгээний хэрэгсэл одоогоор бүрэн төлөвшөөгүй бөгөөд хөгжиж байгаа гэж үзэж болно.

Судалгаанд хамрагдсан 11 үнэлгээний хэрэгслийг харьцуулан шинжлэхэд сургалтын ерөнхий мэдээлэл, үнэлгээ, суралцагчийн оролцоо, сургалтын материал зэрэг бүлгүүд бүх хэрэгсэлд өндөр давтамжтай илэрч, онлайн сургалтын чанарын нийтлэг хэмжүүр болох нь тодорхойлогдлоо. Харин технологи, хүртээмж, суралцагчийн дэмжлэг нь хэрэгслийн зорилго, хэрэглэх орчин, платформын онцлогоос хамааран харилцан адилгүй тусгагджээ. Түүнчлэн, хэрэгслийн хувьд үнэлгээний аргачлал, найдвартай байдал, хүчинтэй байдлын талаарх мэдээлэл хомс байгаа нь цаашид судалгаанд суурилсан, ил тод, уян хатан үнэлгээний хэрэгсэл хөгжүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Иймд цаашдын судалгаа нь олон улсын туршлагыг суурь болгон, Монголын нөхцөлд нийцсэн үнэлгээний хэрэгсэл боловсруулах, эмпирик баталгаажуулалт хийхэд чиглэх ёстой. Ийм хэрэгсэл

нь онлайн сургалтын чанарыг тасралтгүй сайжруулах, суралцагчийн сурлагын амжилтыг нэмэгдүүлэх, хүртээмжийг дэмжих стратегийн ач холбогдолтой.

Ийм хэрэгслийг боловсруулахдаа олон улсын хэрэгсэлд нийтлэг илэрсэн шалгуурын бүлгүүдийг (ерөнхий мэдээлэл, үнэлгээ, суралцагчийн оролцоо, сургалтын материал) суурь болгон авч, харин технологи, хүртээмж, суралцагчийн дэмжлэг зэрэг шалгууруудыг Монголын дээд боловсролын байгууллагын нөхцөл, сургалтын орчинд нийцүүлэн тусгах нь зүйтэй. Мөн уг хэрэгслийг туршилтаар хэрэгжүүлж, найдвартай байдал, хүчин төгөлдөр байдлыг эмпирик аргаар шалган баталгаажуулах замаар бодит хэрэглээнд нэвтрүүлэх боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Altangerel, O., Davaa, J., Shiilegmaa, Ya., Chingee, D., & Bolorsaikhan, O. (2023). Results of some researches on digital learning and teaching in higher education. ResearchGate. <https://www.researchgate.net/publication/369910976>
- Alturkistani, A., Lam, C., Foley, K., Stenfors, T., Blum, E. R., Van Velthoven, M. H., & Meinert, E. (2020). Massive open online course evaluation methods: Systematic review. *Journal of Medical Internet Research*, 22(4), e13851. <https://doi.org/10.2196/13851>
- Badamsuren, B., & Munkhtuya, L. (2019). Issues on developing the methodology of e-content training. *Lavai – International Journal of Education*, 15(22), 1–15. <https://www.researchgate.net/publication/392079038>
- Badamsuren, B., Munkhtuya, L., Jadamba, B., & Nyamsuren, T. (2025). The impact of the flipped learning method on students' academic achievement. *Mongolian Journal of Educational Research*, 30(2), 15–28. <https://journal.mnier.mn/index.php/research/article/view/95/59>
- Baldwin, S. J., Ching, Y. H., & Hsu, Y.-C. (2019). A review of the Canvas Course Evaluation Checklist (CCEC). *Online Learning*, 23(4), 1–19. <https://eric.ed.gov/?id=EJ1223648>
- Buyandelger, B., Munkhbat, Sh., Gerelmaa, B., Bayarsaikhan, B. The study on e-learning readiness of students in vocational education and training institutions. (2022). *Mongolian Journal of Educational Research*, 27(1). 44-52. <https://doi.org/10.56380/v27.1.4>
- Batkhuuyag, T. Munkerdene, D (2024). Result of Pilot Research and Implementation to Improve the Quality of Management Information Systems in Higher Educational Institutions (MNUE) *Mongolian Journal of Educational Research*, 29(2). <https://doi.org/10.56380/mjer.v29.2.4>
- Briones, M. R., Prudente, M., & Errabo, D. D. (2023). Stakeholders' perspective on the quality of virtual learning material in Google Classroom. *International Journal of Technology in Education*, 6(4), 736–759. <https://doi.org/10.46328/ijte.571>
- Dorjpurev, B., & Nomin-Erdene, Ts. (2020). Ways to improve the quality and Accessibility of e-learning. *Higher Education New Era Journal*, 2(1), 45–52. <https://higher-education-new-era-journal.mn/assets/front/images/pdf/articles/1AoeCGRarCuDM8ZgKJQ6q1nN8rY211tjOT4T3xCr.pdf>
- Lin, N. T., Li, H., Mui Perez, C., Yan, Y., & Flammer, K. (2023). Assessing student perceptions and performance in digital learning spaces through an equity lens. *The Journal of Applied Instructional Design*, 12(2), 78–82.
- Lynch, S., & Gaston, T. (2020). Quality Matters impact on student outcomes in an online program. *Journal of Educators Online*, 17(2). <https://www.thejeo.com>
- Martin, F., Budhrani, K., Kumar, S., & Ritzhaupt, A. (2019). Award-winning faculty online teaching practices: Roles and competencies. *Online Learning*, 23(1), 184–205. <https://doi.org/10.24059/olj.v23i1.1329>
- Martin, F., Sun, T., & Westine, C. D. (2020). A systematic review of research on online teaching and learning from 2009 to 2018. *Computers & Education*, 146, 103750. <https://doi.org/10.1016/j.compedu.2020.104009>

- Martin, F., Budhrani, K., Kumar, S., & Ritzhaupt, A. (2021). Development and validation of the Online Course Design Elements (OCDE) instrument. *Online Learning Journal*, 25(2), 184–204. <https://files.eric.ed.gov/fulltext/EJ1298023.pdf>
- Matolić, T., Jurakić, D., Greblo Jurakić, Z., Maršić, T., & Pedišić, Ž. (2023). Development and validation of the EDUcational Course Assessment TOOLkit (EDUCATOOL). *Frontiers in Education*, 8, 1314584. <https://doi.org/10.3389/educ.2023.1314584>
- McInnes, R., Hobson, J. E., Johnson, K. L., Cramp, J., Aitchison, C., & Baldock, K. L. (2024). Online course quality evaluation instruments: A scoping review. *Australasian Journal of Educational Technology*, 40(2), 55–75. <https://doi.org/10.14742/ajet.8978>
- Meng, W., Yu, L., Liu, C., Pan, N., Pang, X., & Zhu, Y. (2024). A systematic review of the effectiveness of online learning in higher education during the COVID-19 pandemic period. *Frontiers in Education*, 9, 1334153. <https://doi.org/10.3389/educ.2023.1334153>
- Itgel, M., Badmaanyambu, D., Tserenbat, O., & Odmaa, I. (2022). Examining the reliability and validity of a Mongolian version of the student online learning readiness instrument using exploratory and confirmatory factor analysis. *Journal of University Teaching & Learning Practice*, 19(5).
- Miranda McIntosh. (2023, July 24). Canvas Course Evaluation Checklist v3.0. Instructure Community. https://community.canvaslms.com/t5/Canvas-LMS-Blog/Course-Evaluation-Checklist-v3-0/bap/574446?utm_source
- Morrison, G. R., Ross, S. J., & Morrison, J. R. (2019). *Designing effective instruction* (8th ed.). John Wiley & Sons.
- Munkhdelger, Ts., Nomon, O., Munkhtogtokh, B., Purevdulam, A. (2025). Evaluation of E-Learning: The Case of Mongolian Universities. *International Journal of Research and Innovation in Social Science (IJRISS)*, 9(07), 3687-3696. <https://dx.doi.org/10.47772/IJRISS.2025.907000298>
- Newsome, M. L., Pina, A. A., Mollazehi, M., Al-Ali, K., & Al-Shaboul, Y. (2022). The effect of gender and STEM/non-STEM disciplines on remote learning: A national study of undergraduates in Qatar. *The Electronic Journal of e-Learning*, 20(4), 360–373. <https://www.ejel.org>
- Battsetseg, S., Tungalagtuya, Kh., & Munkhtuya, L. (2024). A solution to challenges faced by teachers in distance learning to improve the quality and accessibility of education. *Lavai – International Journal of Education*, 20(31), 35–46. <https://doi.org/10.5564/lavai.v20i31.3874>
- Otgontsetseg, S., Lodoiravsal, Ch., & Usagawa, T. (2018). Students’ perception and experience of Massive Open Online Courses in Mongolia. *Creative Education*, 9(12), 1818–1828. <https://doi.org/10.4236/ce.2018.912132>
- Gantsetseg, S., Uranchimeg, T., Selenge, E., & Bazarragchaa, S. (2023). Students’ evaluation of e-courses during curfew. *Lavai – International Journal of Education*, 19(29), 42–49. <https://doi.org/10.5564/lavai.v19i29.3210>
- Sun, T., Martin, F., Kim, S. Y., & Westine, C. (2023). Establishing a student evaluation of online teaching and learning framework through analysis of existing instruments. *Online Learning*, 27(1), 356–382. <https://doi.org/10.24059/olj.v27i1.3228>
- Tana, Bayanmunkh, T., Oyunchuluun, Y., Enkhhtuvshin, D., & Enkhbat, C. (2023). A Comparative Study of Face-to-Face and Online Teaching Outcomes in Biology. *Lavai - International Journal of Education*, 19(29), 2–14. <https://doi.org/10.5564/lavai.v19i29.3206>
- Uranchimeg, T., Bazarragchaa, S., & Selenge, E. (2021). The evaluation case study of online course during pandemic period in Mongolia. AIRCC Publishing Corporation. <https://doi.org/10.48550/arXiv.2105.12429>
- Suvdmaa, T., Otgontugs, B., Tsogzolmaa, S. (2016). E-learning in Mongolian higher education. *International Review of Research in Open and Distributed Learning*, 17(2). <https://doi.org/10.19173/irrodl.v17i2.2227>

Suvdmaa, T., Uyanga, S., Otgontugs, B., Narantuya, M., Munkh-Ireedui, B., Oйунбилэг, P. (2023). Factor analysis on e-learning implementation in Mongolian higher education. *iBusiness*, 15(1), 38–59. <https://doi.org/10.4236/ib.2023.151003>

Zimmerman, W. A., Knight, S. L., & McGarity, S. (2020). Evaluating online course quality: A study on implementation of Quality Matters. *American Journal of Distance Education*, 34(4), 293–310. <https://files.eric.ed.gov/fulltext/EJ1277443.pdf>

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Цэндсүрэнгийн Нямсүрэн

 <https://orcid.org/0000-0003-3151-4154>

Байгууллагын нэр: МУБИС, МБУС, Мэдээлэл зүйн тэнхим

Хаяг: УБ хот, СБД, VIII хороо, Бага тойруу-14;

Улс: Монгол

e-mail: nyamsuren@msue.edu.mn

Овог, нэр: Лхагвасүрэнгийн Мөнхтуяа

 <https://orcid.org/0009-0007-6090-676x>

Байгууллагын нэр: МУБИС, Захиргаа, хүний нөөцийн газар

Хаяг: УБ хот, СБД, VIII хороо, Бага тойруу-14;

Улс: Монгол

e-mail: munkhtuya@msue.edu.mn

Овог, нэр: Батсуурийн Бадамсүрэн

 <https://orcid.org/0009-0006-3135-3660>

Байгууллагын нэр: МУБИС, МБУС, Мэдээлэл зүйн тэнхим

Хаяг: УБ хот, СБД, VIII хороо, Бага тойруу-14;

Улс: Монгол

e-mail: badamsuren@msue.edu.mn
